

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **СНАГ-2024/16/НА-СТА-ТЕЗ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2023 он	Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Долгоржав Утас: 261628 Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГА Л.ЦЭДЭВСҮРЭН ТАНАА

### **Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### **Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль шинээр батлагдаж, Ёс зүйн хороо 9 орон тоотойгоор байгуулагдсанаар төрийн албаны ёс зүйн хэм хэмжээ, шаардлагыг тогтоосон эрх зүйн зохицуулалт, тогтолцоог бүрдүүлэх, нийслэл, 21 аймаг, яам, агентлагийн Салбар зөвлөлийн нийт 43 нарийн бичгийн дарга нарыг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтад хамруулан төрийн албаны хүний нөөцийн аудитын гэрчилгээ олгон, Төрийн албаны төв байгууллагаас томилсон хүний нөөцийн аудитын багт төлөөллөөр, гишүүнээр ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Тайлант онд мэдээллийн дагуу төрийг хохиролгүй болгох арга хэмжээ аваагүй 124 албан тушаалтанд холбогдох 1,764.7 сая төгрөгийн үнийн дүн бүхий төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргаснаас шүүхийн шийдвэрийн дагуу төрийн санд 253.7 сая төгрөг төвлөрүүлсэн бөгөөд 35 иргэний буруутай албан тушаалтаас гаргуулах 350.0 сая төгрөгийг албадан гаргуулахаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хандсан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан 2 хөтөлбөрийн хүрээнд 6 арга хэмжээний зорилтот түвшнийг тусгасан бөгөөд хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнг 95.0 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАГДЖАВ

## АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>167,433.5</b>	<b>358,742.5</b>
МӨНГӨН ХӨРӨНГӨ	53,208.2	280,842.0
АВЛАГА	78,497.2	1,140.5
БАРАА МАТЕРИАЛ	35,728.2	76,760.1
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,792,453.0</b>	<b>2,185,252.2</b>
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,792,453.0	2,185,252.2
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,959,886.6</b>	<b>2,543,994.7</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>67,437.7</b>	<b>268,290.9</b>
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	67,437.7	268,290.9
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,892,448.8</b>	<b>2,275,703.8</b>
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО	1,892,448.8	2,275,703.8
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,959,886.6</b>	<b>2,543,994.7</b>

### 2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>2,564,108.6</b>	<b>4,149,402.2</b>
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	40,043.8	10,150.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,524,064.8	4,139,252.2
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,520,081.6</b>	<b>3,772,790.9</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,520,081.6</b>	<b>3,772,790.9</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,331,060.4</b>	<b>3,268,540.2</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,301,025.4	1,748,940.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	164,040.2	215,706.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,517.1	13,995.5
Хангамж, бараа материалын зардал	117,613.1	129,362.1
Эд хогшил, урсгал засварын зардал	1,471.7	24,106.3
Томилолт, зочны зардал	0.0	14,541.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	436,427.6	588,567.9
Бараа үйлчилгээний бусад зардал	291,965.3	533,320.2
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>189,021.2</b>	<b>504,250.7</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>44,027.1</b>	<b>376,611.3</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>44,027.1</b>	<b>376,611.3</b>

### 3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>2,594,108.6</b>	<b>4,460,277.2</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>30,210.0</b>	<b>321,025.0</b>
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,563,898.6</b>	<b>4,139,252.2</b>
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,584,201.3</b>	<b>3,471,264.6</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,584,201.3</b>	<b>3,471,264.6</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,395,180.1</b>	<b>2,899,676.2</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,342,109.9	1,688,500.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	164,040.2	244,971.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,517.1	13,995.5
Хангамж, бараа материалын зардал	92,069.6	130,406.0
Эд хогшил, урсгал засварын зардал	1,471.7	24,106.3
Томилолт, зочны зардал	0.0	15,741.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	741,128.6	588,567.9
Бараа үйлчилгээний бусад зардал	35,843.0	193,386.7
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>189,021.2</b>	<b>571,588.4</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>9,907.3</b>	<b>989,012.6</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>9,591.5</b>	<b>761,378.8</b>
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>9,591.5</b>	<b>761,378.8</b>
Дотоод эх үүсвэрээр	9,591.5	761,378.8
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(9,591.5)</b>	<b>(761,378.8)</b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>315.8</b>	<b>227,633.7</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	52,892.4	53,208.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	53,208.2	280,842.0

### 4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,234,279.5</b>		<b>1,234,279.5</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	614,142.3		614,142.3
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,848,421.8</b>		<b>1,848,421.8</b>
Тайлант үеийн үр дүн	44,027.1		44,027.1
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,892,448.8</b>		<b>1,892,448.8</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	6,643.7		6,643.7
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,899,092.5</b>		<b>1,899,092.5</b>
Тайлант үеийн үр дүн	376,611.3		376,611.3
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,275,703.8</b>		<b>2,275,703.8</b>

**5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,856,414,600.00</b>	<b>3,469,861,621.54</b>	<b>386,552,978.46</b>	<b>89.98</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,856,414,600.00</b>	<b>3,469,861,621.54</b>	<b>386,552,978.46</b>	<b>89.98</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,687,371,600.00</b>	<b>3,340,769,001.54</b>	<b>346,602,598.46</b>	<b>90.60</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,947,967,100.00</b>	<b>1,653,158,588.91</b>	<b>294,808,511.09</b>	<b>84.87</b>
210101	Үндсэн цалин	1,143,409,200.00	914,571,100.74	228,838,099.26	79.99
210102	Нэмэгдэл	517,960,500.00	384,083,627.69	133,876,872.31	74.15
210103	Унаа хоолны хөнгөлөлт	156,426,600.00	170,761,172.19	(14,334,572.19)	109.16
210104	Урамшуулал	130,170,800.00	183,742,688.29	(53,571,888.31)	141.2
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>243,495,700.00</b>	<b>243,495,700.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	165,577,100.00	165,577,100.00	0.00	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	19,479,600.00	19,479,600.00	0.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,583,800.00	15,583,800.00	0.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,895,900.00	3,895,900.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	38,959,300.00	38,959,300.00	0.00	100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>13,995,500.00</b>	<b>13,995,500.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210304	Байрны түрээс	13,995,500.00	13,995,500.00	0.00	100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>122,649,600.00</b>	<b>120,732,610.66</b>	<b>1,916,989.34</b>	<b>98.44</b>
210401	Бичиг хэрэг	20,351,500.00	20,351,500.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	32,246,600.00	32,235,054.00	11,546.00	199.96
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	23,335,600.00	22,868,856.66	466,743.34	98.00
210404	Ном, хэвлэл	31,027,200.00	29,588,500.00	1,438,700.00	95.36
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,688,700.00	15,688,700.00	0.00	100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>431,803,400.00</b>	<b>428,193,210.00</b>	<b>3,610,190.00</b>	<b>99.16</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	288,933,200.00	286,560,110.00	2,373,090.00	99.18
210602	Тавилга	120,176,100.00	118,939,000.00	1,237,100.00	98.97
210604	Урсгал засвар	22,694,100.00	22,694,100.00	0.00	100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>15,141,500.00</b>	<b>15,141,500.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210702	Дотоод албан томилолт	15,141,500.00	15,141,500.00	0.00	100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>650,034,200.00</b>	<b>636,353,371.97</b>	<b>13,680,828.03</b>	<b>97.90</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	225,231,500.00	224,375,100.00	856,400.00	99.62
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,000,000.00	6,265,000.00	735,000.00	89.50
210803	Даатгалын үйлчилгээ	63,700.00	57,915.00	5,785.00	90.92
210804	Тээврийн хэрэгслийн татвар	135,800.00	135,500.00	300.00	99.78
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	63,700.00	57,915.00	5,785.00	90.92
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	407,539,500.00	405,081,941.97	2,457,558.03	99.40

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	10,000,000.00	380,000.00	9,620,000.00	3.80
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>262,284,600.00</b>	<b>229,698,520.00</b>	<b>32,586,080.00</b>	<b>87.58</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	147,351,500.00	116,333,100.00	31,018,400.00	78.95
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	114,933,100.00	113,365,420.00	1,567,680.00	98.64
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>169,043,000.00</b>	<b>129,092,620.00</b>	<b>39,950,380.00</b>	<b>76.37</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>169,043,000.00</b>	<b>129,092,620.00</b>	<b>39,950,380.00</b>	<b>76.37</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	40,500,000.00	40,500,000.00	0.00	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	118,397,900.00	78,920,625.0	39,477,275.00	66.66
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,145,100.00	9,671,995.00	473,105.00	95.34
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,856,414,600.00</b>	<b>3,469,861,621.54</b>	<b>386,552,978.46</b>	<b>90.00</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,856,414,600.00</b>	<b>3,469,861,621.54</b>	<b>386,552,978.46</b>	<b>90.00</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	3,856,414,600.00	3,469,861,621.54	386,552,978.46	90.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>100.00</b>
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>61</b>	<b>49</b>	<b>12</b>	<b>80.33</b>
620001	Удирдах ажилтан	11	9	2	81.82
620002	Гүйцэтгэх ажилтан	50	40	10	80.00

**6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>322,460,022.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>322,460,022.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>320,277,343.38</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>35,341,972.28</b>
210101	Үндсэн цалин		35,341,972.28
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>1,476,000.00</b>
210201	Тэтгэврийн даатгал		1,020,000.00
210202	Тэтгэмжийн даатгал		120,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		96,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал		240,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>9,673,379.84</b>
210402	Тээвэр, шатахуун		750,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		2,927,379.84
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		5,996,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		<b>600,000.00</b>
210702	Дотоод албан томилолт		600,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>273,185,991.26</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		273,185,991.26
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>2,182,678.62</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>2,182,678.62</b>
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		2,182,678.62
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>322,460,022.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>322,460,022.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		322,460,022.00

## АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 4,921.3 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 4,903.8 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж залруулагдаагүй 17.5 сая төгрөгийн алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн CTSYSTEM 6.5 программын алдаатай тооцооллоос балансын данс тус бүрийн эхний болон эцсийн үлдэгдэл нийт 4,840.4 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн;
- Үндсэн хөрөнгийн дансанд 15.4 сая төгрөгийн хөрөнгийг ангилал зөрүүлэн бүртгэсэн;
- Бэлэн бүтээгдэхүүний дансанд 48.0 сая төгрөгийн бичиг хэргийн, аж ахуй, сэлбэг хэрэгслийг буруу ангилан бүртгэсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 19 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах 3 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 19.0 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон 37.7 сая төгрөгийн ерөнхий материаллаг байдлын түвшингээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Төрийн албаны зөвлөл тайлант хугацааны эцэст 14.6 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.1 "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өмнө үүсгэсэн өр төлбөрөө барагдуулах, төсвийг зохистой удирдаж авлага, дахин авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах, цаашид зөрчлийг давтахгүй ажиллах.

#### 2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд өөрийн хөрөнгөөр бэлтгэсэн 17.5 сая төгрөгийн тавилга эд хогшлыг тоног төхөөрөмжийн дансанд буруу ангилан бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-т "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4."Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2."бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 4.30-дахь заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 4.30-дахь заалтын дагуу хөрөнгийг зөв ангилан бүртгэх, цаашид зөрчлийг давтахгүй ажиллах.

#### 3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинж чанар агуулсан 4.4 сая төгрөгийн хөрөнгийг буруу ангилан бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн

5.1.5-т "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4."Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2."бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 4.16-дахь заалттай нийцэхгүй байна. .

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 4.30-дахь заалтын дагуу хөрөнгийг зөв ангилан бүртгэх, цаашид зөрчлийг давтахгүй ажиллах.

#### **4. Орлого төлөвлөлттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх төсвийн зарчмын дагуу жил бүр байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бүрдүүлдэг орлогыг төсвийн төсөлд тусгаагүй, төлөвлөгөө батлуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "Төсвийн төслийг боловсруулахад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагаас гадна дараах шаардлага тавигдана: 27.1.7 "орлого, зарлагыг дотоод гүйлгээнээс бусад нийт гүйлгээний дүнгээр төлөвлөж, бүртгэж, тайлагнах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн орлогыг зөв төлөвлөж, зарцуулалтад хяналт тавих, цаашид зөрчлийг давтахгүй ажиллах.

**АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

*/сая төгрөгөөр/*

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс	Зөвлөмж өгсөн		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Дүн	Тоо	Дүн
								Тоо			
1	Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн CTSYSTEM 6.5 программын алдаатай тооцооллоос үүссэн балансын данс тус бүрийн эхний болон эцсийн үлдэгдэл нийт 4,840.4 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. Үүнд: мөнгөн хөрөнгө 334.1 сая төгрөг, авлага 79.6 сая төгрөг, өглөг 335.7 сая төгрөг, үндсэн хөрөнгө 3,978.5 сая төгрөг, бараа материал 112.5 сая төгрөг.	1	4,840.4	1	4,840.4			1	4,840.4		
2	Үндсэн хөрөнгийн дансанд 15.4 сая төгрөгийн хөрөнгийг ангилал зөрүүлэн бүртгэсэн байна.	1	15.4			1	15.4	1	15.4		
3	Тайлант онд худалдан авсан 17.4 сая төгрөгийн тавилга эд хогшлыг тоног төхөөрөмжийн дансанд буруу ангилан бүртгэсэн байна.	1	17.5			1	17.5			1	17.5
4	Бэлэн бүтээгдэхүүний дансанд 48.0 сая төгрөгийн бичиг хэргийн, аж ахуй, сэлбэг хэрэгслийг буруу ангилан бүртгэсэн байна.	1	48.0			1	48.0	1	48.0		
	<b>Дүн</b>	<b>3</b>	<b>4,921.3</b>	<b>1</b>	<b>4,840.4</b>	<b>2</b>	<b>80.9</b>	<b>3</b>	<b>4,903.8</b>	<b>1</b>	<b>17.5</b>

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төрийн албаны зөвлөл тайлант хугацааны эцэст 14.6 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн.	1	14.6					1	14.6
2	Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинж чанар агуулсан 4.4 сая төгрөгийн хөрөнгийг буруу ангилан бүртгэсэн байна.	1	4.4					1	4.4
3	Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх төсвийн зарчмын дагуу жил бүр байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бүрдүүлдэг орлогыг төсвийн төсөлд тусгаагүй, төлөвлөгөөнд батлуулаагүй байна.	1	0.0					1	
	<b>Дүн</b>	<b>3</b>	<b>19.0</b>					<b>3</b>	<b>19.0</b>